



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Их-Уул сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/134/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: bat-undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаяг

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Уластай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

дод 4.03.14 № д33

танай _____-ны № _____-т

ИХ-УУЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА О.ОДОНТУЯА-д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Их-Уул сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их-Уул сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023 оны санхүүжилтийг өмнөх онтой харьцуулахад 1,949,788.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь татвар болон татварын бус орлого 53,188.5 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 485,491.3 мянган төгрөгөөр, цалин нэмэгдсэнтэй холбогдуулан орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 165,757.5 мянган төгрөгөөр, татварын орлогын санхүүжилт 247,493.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн болон улсын төсөвт байгууллагын тогтмол зардал 886,423.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 111,434.4 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр олгосон зэрэгтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Их-Уул сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд сумын Засаг даргын үйл ажиллагаатай шууд хамааралтай алдаа, зөрчил 71.8 хувиар буурсан байна.

Audit(D)A4-тоот/2024

01.03.2024

Бусад асуудлын хэсэг

Их-Уул сумын Засаг дарга тайлант онд татварын орлогыг 558,214.8 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл нь 598,350.0 мянган төгрөг буюу 7.2 хувиар давсан байна. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт 70 иргэнд 51,357.8 мянган төгрөгийг буцаан олгосон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	697,278.5	914,571.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	183,687.6	178,210.4
33	АВЛАГА	345,271.8	437,006.5
35	БАРАА МАТЕРИАЛ	168,319.1	299,354.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,027,578.4	1,540,201.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,027,578.4	1,540,201.0
39200	Биет хөрөнгө	993,110.4	1,506,453.0
39300	Биет бус хөрөнгө	34,468.0	33,748.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,724,857.0	2,454,772.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,724,857.0	2,454,772.5
51	Засгийн газрын хувь оролцоо	1,724,857.0	2,454,772.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	391,848.4	391,848.4
51200	Хуримтлагдсан үр дүн	1,143,342.7	1,873,258.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	189,665.9	189,665.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,724,857.0	2,454,772.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,300,109.6	3,546,859.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	444,520.0	491,905.5
110	Орлогын албан татвар	297,300.6	366,138.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	335,097.4	417,496.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-37,796.8	-51,357.9
113	Хөрөнгийн албан татвар	63,710.7	41,737.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,508.7	84,029.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	493,337.1	745,045.9
120	Нийтлэг татварын бус орлого	493,337.1	745,045.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,362,252.5	2,309,908.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,544,480.0	2,075,492.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,544,480.0	2,075,492.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	805,788.1	1,991,596.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	323,299.5	491,397.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,404.9	61,921.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,540.2	70,718.7
2104	Хангамж, бараа материалын зардал	68,192.8	86,165.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,081.0	19,725.1
2107	Томиллолт, зочны зардал	7,197.5	10,897.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,915.9	94,422.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	282,156.2	1,156,348.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	738,691.8	83,896.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	755,629.7	1,471,367.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,660,713.9	741,451.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-5,905,084.3	729,915.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,647,320.6	7,647,320.6
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,724,857.0	1,724,857.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,629,941.2	7,629,941.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-17,379.3	-17,379.3
9	Тайлант үеийн үр дүн	-5,905,084.3	-5,905,084.3
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,724,857.0	1,724,857.0
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,454,772.5	2,454,772.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,724,857.0	1,724,857.0
19	Тайлант үеийн үр дүн	729,915.6	729,915.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,983,553.4	2,974,454.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	444,520.0	491,905.5
110	Орлогын албан татвар	297,300.6	366,138.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	335,097.4	417,496.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-37,796.8	-51,357.9
113	Хөрөнгийн албан татвар	63,710.7	41,737.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,508.7	84,029.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,816.7	4,244.9
1181	Газрын төлбөр	2,688.2	22,589.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	73,003.9	57,194.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	176,780.9	172,640.7
120	Нийтлэг татварын бус орлого	176,780.9	172,640.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,362,252.5	2,309,908.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,385,950.3	1,986,793.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,385,950.3	1,986,793.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	646,280.3	1,902,897.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,574.3	492,403.0
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	41,655.6	61,286.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,817.7	70,718.7
2104	Хангамж, бараа материалын зардал	36,954.7	54,839.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,339.4	6,284.6
2107	Томиллолт, зочны зардал	7,047.5	10,189.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,615.8	185,864.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	157,275.3	1,021,311.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	739,670.0	83,896.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	597,603.1	987,660.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	653,545.0	946,906.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	653,545.0	946,906.4
2200	Дотоод эх үүсвэрээр	653,545.0	946,906.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-653,545.0	-946,906.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-199,056.0	-46,231.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЗЭЭЛ	199,056.0	46,231.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-254,997.9	-5,477.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	438,685.4	183,687.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	183,687.6	178,210.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,887,644.6	2,611,253.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,816,043.5	1,750,306.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,755,796.8	1,690,059.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	504,926.6	492,402.9
210101	Үндсэн цалин	354,203.9	311,002.2
210102	Нэмэгдэл	137,697.1	136,815.4
210104	Урамшуулал	13,025.6	44,585.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,116.5	61,286.1
210201	Тэтгэврийн даатгал	42,918.7	41,804.9
210202	Тэтгэмжийн даатгал	5,049.3	4,919.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,040.0	3,935.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,009.9	964.4
210205	Эрүүл мэндийн даатгал	10,098.6	9,662.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	938,008.5	928,375.7
210301	Гэрэл, цахилгаан	62,731.3	53,041.7
210302	Түлш, халаалт	868,112.7	873,236.1
210303	Цэвэр, бохир ус	7,164.5	2,097.8
2104	Хангамж, бараа материалын зардал	38,985.1	38,648.3
210401	Бичиг хэрэг	6,386.2	6,369.0
210402	Тээвэр, шатахуун	28,179.2	28,220.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,419.7	4,058.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,022.2	33,017.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000.0	1,997.9
210602	Тавилга	8,500.0	8,500.0
210604	Урсгал засвар	22,522.2	22,520.0
2107	Томилолт, зочны зардал	9,273.5	9,249.8
210702	Дотоод албан томилолт	9,273.5	9,249.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,434.6	2,819.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,300.0	1,875.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	710.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	469.1	169.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.7	182.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73.8	0.0
210807	Газрын төлбөр	638.3	592.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.7	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,029.8	124,259.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	159,376.4	119,759.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,653.4	4,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,246.7	60,246.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,246.7	60,246.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,246.7	60,246.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	855,541.1	814,716.0
223001	Бусад хөрөнгө	855,541.1	814,716.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЗЭЭЛ	216,060.0	46,231.4
230001	Эргэж төлөгдөх зээл	216,060.0	46,231.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,887,644.6	2,708,294.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,516,518.3	2,594,847.5
320001	Орон нутгийн төсвөөс	1,745,977.2	1,824,306.4
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	770,541.1	770,541.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	371,126.3	113,446.4

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	113,446.4
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	371,126.3	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	9,106.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	106,146.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	347,659.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	347,659.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	345,028.23
2104	Хангамж, бараа материалын зардал	16,191.05
210402	Тээвэр, шатахуун	16,171.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,338.60
210604	Урсгал засвар	2,338.60
2107	Томилолт, зочны зардал	940.00
210702	Дотоод албан томилолт	940.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	283,041.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	283,041.21
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,517.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,517.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,631.27
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,631.27
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,631.27
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	345,028.23
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	345,028.23
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	345,028.23
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-2,631.27
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,631.27

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Их-Уул сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Эрхэм зорилго: Төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх, үндсэн үүргээ мөрдлөг болгон, УИХ, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, хэлтэс агентлагуудаас гаргасан тогтоол шийдвэр, заавар журам, албан даалгаврыг хэрэгжүүлэх, сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хийж хэрэгжүүлэхээр зорилтуудыг биелүүлэхэд оршино.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 131 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 85.04 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Их-Уул сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их-Уул сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Их-Уул сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 729,915.5 мянган төгрөгөөр буюу 42.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	183,687.6	178,210.4	(5,477.2)
Авлага	345,271.8	437,006.5	91,734.7
Бараа материал	168,319.1	299,354.6	131,035.5
Үндсэн хөрөнгө	1,027,578.4	1,540,201.0	512,622.6
Нийт хөрөнгө	1,724,857.0	2,454,772.5	729,915.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,724,857.0	2,454,772.5	729,915.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,724,857.0	2,454,772.5	729,915.5

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 178,210.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,477.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	183,687.6	178,210.4	(5,477.2)
Дүн	183,687.6	178,210.4	(5,477.2)

Эх сурвалж: Их-Уул сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 5,477.2 мянган төгрөгөөр буурсан нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн барагдаж дансанд төвлөрсөн болон 2022 оны давсан орлогоос сумын Орон нутгийн хөгжлийн сан болон Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд төсөв нэмж зарцуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил илрээгүй

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 437,006.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 91,734.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	370.7	370.7
Байгууллагаас авах авлага	291.4	139,700.0	139,408.6
Хувь хүмүүсээс авах авлага	344,980.4	296,935.7	(48,044.7)
Дүн	345,271.8	437,006.5	91,734.7

Эх сурвалж: Их-Уул сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оны үлдэгдлээс мянган төгрөгөөр 91,734.7 өссөн нь ажиллагсадтай холбоотой болон байгууллагаас авах авлага 139,779.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн, Хоршоо хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага 48,044.7 мянган төгрөгөөр буурсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ нь тайлант онд үүссэн 80,000.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, 173.6 мянган төгрөгийн НДШ-ийн авлагыг дутуу тусгасан алдааг аудитын явцад залруулсан байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 299,354.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 131,035.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	52,952.8	150,099.8	97,147.0
Тусгай зориулалтын материал	52,952.8	150,099.8	97,147.0
Хангамжийн материал	108,528.3	142,416.8	33,888.5
Бичиг хэргийн материал	3,220.0	4,063.1	843.1
Аж ахуйн материал	105,308.3	138,353.8	33,045.5
Мал амьтад	6,838.0	6,838.0	0.0
Дүн	168,319.1	299,354.6	131,035.5

Эх сурвалж: Их-Уул сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 131,035.5 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-ийн хөрөнгөөр 144,040.3 мянган төгрөгийн аж ахуйн материал бэлтгэж, данс бүртгэлд тусгасан, тайлант онд 160,838.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 173,843.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материалтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,540,201.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 512,622.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	993,110.5	1,506,453.0	628,462.9
Барилга, байгууламж, орон сууц	759,130.6	1,045,386.6	286,256.0
Авто-тээврийн хэрэгсэл	303,738.8	433,038.8	129,300.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	279,429.5	337,329.5	57,900.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	49,757.7	70,371.0	20,613.3
Бусад үндсэн хөрөнгө	289,184.3	423,577.9	134,393.6
Ном	264.0	264.0	0.0
Биет бус хөрөнгө	34,468.0	33,748.0	0.0
Программ хангамж	3,800.0	3,800.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	32,668.0	32,668.0	0.0
Хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	-690,394.5	-806,234.8	-115,840.3
Дүн	1,027,578.4	1,540,201.0	512,622.6

Эх сурвалж: Их-Уул сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 512,622.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 132,190.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 529,671.2 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдсэн, 33,398.7 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, тайлант оны элэгдлийн зардалд 149,239.0 мянган төгрөгийг тооцож, бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ нь Тайлант онд худалдаж авсан хөрөнгийг үнэ төлбөргүй шилжиж ирснээр бүртгэж тайлагнасан, 3,900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тавилга эд хогшил дансанд бүртгэсэн, тайлант оны элэгдлийн зардлыг 10,829.9 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон зэрэг алдаа илэрсэнд залруулга хийсэн байна.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр данстай холбоотой бүртгэл байхгүй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,454,772.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 729,915.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	391,848.4	391,848.4	0.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	391,848.4	391,848.4	0.0
Хуримтлагдсан үр дүн	1,143,342.7	1,873,258.3	729,915.6
Өмнөх үеийн үр дүн	7,048,426.9	1,143,342.7	(5,905,084.2)
Тайлант үеийн үр дүн	(5,905,084.3)	729,915.6	6,634,999.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	189,665.9	189,665.9	0.0
Дүн	1,724,856.9	2,454,772.5	729,915.6

Эх сурвалж: Их-Уул сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 729,915.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагчид тус тусдаа төсвийн төслийг боловсруулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн холбогдох хэлтэст хүргүүлэн, нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 32 дугаар тогтоолоор Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 2,509,759.7 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 1,662,082.5 мянган төгрөг байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 223,750.3 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 576,573.8 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, 847,677.2 мянган төгрөгийг мянган төгрөгийг Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс, 502,672.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 216,060.0 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс, 143,026.4 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2023 оны төсвийн тодотголоор сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 123,723.8 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 193,967.3 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардлыг 37,226.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 07 сарын 05-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг тодотгож, 2,915,945.8 мянган төгрөг болсон байна.

Гүйцэтгэлээр санхүүгийн дэмжлэгээс 307,915.4 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 770,541.1 мянган төгрөгийн, Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 886,423.4 мянган төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 113,446.4 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 512,494.0 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 127,295.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 179,350.6 мянган төгрөг дутуу байна. Энэ нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 48,965.7 мянган төгрөгөөр дутуу олгогдсон, ИТХ, ЗДТГ-ын санхүүжилтийг дутуу олгосон зэрэг нь нөлөөлж байна.

д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Санхүүгийн дэмжлэг	356,881.1	307,915.4	48,965.7
2	Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	770,541.1	770,541.1	0.0
3	Татварын болон татварын бус орлого	512,494.0	512,494.0	0.0
4	Урьд оны үлдэгдэл	146,765.2	117,473.7	29,291.5
5	Үндсэн үйл ажиллагааны орлого	216,060.0	113,446.4	102,613.6
6	Улсын төсөвт байгууллагын тогтмол зардал	884,903.2	886,423.4	(1,502.2)
ДҮН		2,887,644.6	2,708,294.0	179,350.6

Татварын болон татварын бус орлогоор 598,350.0 мянган төгрөгийг бүрдүүлж, татварын буцаан олголтод 51,357.8 мянган төгрөгийг, санхүүжилтэд 512,494.0 мянган төгрөгийг олгож, 34,498.2 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд байршуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,611,253.8 мянган төгрөг буюу 90.4 хувьтай байгаа нь нь сумын ИТХ-ын төсөвт БИНХ-ын хурал даргалагчийн урамшууллыг хэт өндөр төлөвлөсөн, 2 дугаар Цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардлыг хэмнэсэн, Орон нутгийн нөөц хөрөнгө, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хэмнэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим ажлыг хийгээгүй, Хоршоо хөгжүүлэх сангаас төлөвлөсөн хэмжээнд зээл олгоогүй, ИТХ, ЗДТГ-т санхүүжилт дутуу олгосон зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*/мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	129,207.0	114,818.4	14,388.6	88.9%
2	Засаг даргын Тамгын газар	800,413.1	758,082.7	42,330.4	94.7%
3	Орон нутгийн хөгжлийн сан	855,541.1	814,716.0	40,825.1	95.2%
4	Хоршоо хөгжүүлэх сан	216,060.0	46,231.4	169,828.6	21.4%
5	Улсын төсөвт байгууллагын тогтмол зардал	886,423.4	877,405.3	9,018.1	99.0%
ДҮН		2,887,644.6	2,611,253.8	276,390.8	90.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 347,659.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 345,028.3 мянган төгрөгийг тээвэр шатахуун, шуудан холбоо, урсгал засвар, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж болон бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, 2,631.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН**4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Их-Уул сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Их-Уул сумын Засаг дарга нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 1/18 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,034,379.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 45,515.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 34,136.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 19 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Их-Уул сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй, зөвлөмж өгөгдөөгүй, дотоод хяналттай холбоотой 78,538.5 мянган төгрөгийн зөрчилд аймгийн Засаг даргад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн боловч хугацаандаа хэрэгжээгүй тул дараагийн шатны төсөв захирагчид шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-
Хариуцлага тооцох албан шаардлага	1	78,538.5	-	-	0%
Нийт дүн	1	78,538.5	-	-	0%

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн	
Дүн													

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД

АТА0066 9039376
0721196809

Огноо: 2024-03-25